

| ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР   |             |   |   |          |   |  |
|--|-------------|---|---|----------|---|--|
| Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Тамгын газарт хяналттай байгаа хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалтууд |             |   |   |          |   |  |
| Шийдвэрийн д/д   | Заалтын д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар   | Холбогдох заалтын агуулга   | Төсөв    | Хэрэгжилт   |  |
| ЗГ-ын албан даалгавар  |             |   |   |          |   |  |
| 1  | 1           | Цахим шилжилтийг эрчимжүүлэх тухай<br>2022-07-04<br>Дугаар<br>2022_3                      | 4. Хуульд ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллийг байгууллагын цахим хуудсанд тухай бүр нийтэлж байхыг Засгийн газрын гишүүд, хууль, хяналтын байгууллагын удирдлага, Засгийн газрын агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, терийн ёмчтэй хуулийн этгээдийн Гүйцэтгэх захидал нарт тус тус даалгасугай.   | Төсөвтүү | "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль"-ийн 8 дугаар зүйлд заагдсан терийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, терийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгоор дүүргийн чиг үүрэг, старатеги, зохион байгуулалтын мэдээллийг Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын chingeltei.gov.mn цахим хуудас болон "Чингэлтэй дүүрэг" фейсбуук пэйж хуудсанд байршуулж тухай бүр шинэчлэн ажиллаж байна.   |  |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл   |             |   |   |          |   |  |
| 2  | 2           | 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдөр 33 дугаар тэмдэглэл<br>2022-06-15<br>Дугаар<br>2022_33 | XIII.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, өнөөгийн нөхцөл байдлын талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:<br><br>1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахтай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт даалгав:<br><br>1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд болон салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хяналт тавих, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааг зохих журмын дагуу дэмжих ажиллах;<br><br>1.2. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн хуралдааны 34 дүгээр тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэх;<br><br>1.3. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн харилцаанд тэгш оролцох эрхийг хангах, хамгаалах хүрээнд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хангуйж, хяналт тавьж ажиллах; | Төсөвтүү | Дүүргийн Засаг даргын 2021 оны A/197 дугаар захирамжаар "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөл"-ийг байгуулсан. Салбар зөвлөлийн 2022 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг дүүргийн Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж, төлөвлөгөөний хэрэгжилтийг улирал тутамд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн Ерөнхий газарт хүргүүлэн ажиллаж байна. Мен дүүргийн Засаг даргын 2022 оны A/34 дүгээр захирамжаар дүүргийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүдийг шинэчлэн байгуулж, тайлант хугацаанд 10 удаа хуралдаж, нийт 364 хүүхдэд байнгын асаргаа тогтоож, халамжийн болон боловсролын үйлчилгээнд хамруулж ажиллалаа. |  |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл   |             |   |   |          |   |  |

|   |   |  |                  |  |
|---|---|--|------------------|--|
| 3 | 3 | <p>2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр 60 дугаар тэмдэглэл 2021-11-17 Дугаар 2021_60</p> <p>XIII.2. Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангасан дүнгийн талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав.</p> <p>Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад даалгав:</p> <p>3. Улсын хэмжээнд мал, амьтны гоц халдварт өвчиний тархалт их байгаатай холбогдуулан мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамрагдсан малыг улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын бүс нутаг, хилийн зурvas газар, улсын тусгай хамгаалалттай газарт отроор өвөлжилж хаваржуулах ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулахыг аймаг, нийслэлийн бүх шатны Засаг дарга нарт;</p> | 9,750,000 төгрөг | <p>3. Сангийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны A/118, A/201 дүгээр Хамтарсан тушаал, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 14/05 дугаар тогтоол, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2022 оны A/28 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2022 оны A/295 дугаар захирамж, Нийслэлийн Мал эмнэлгийн газрын даргын 2022 оны A/17 дугаар тушаал, дүүргийн Засаг даргын 2022 оны A/114 дүгээр захирамжийг тус тус үндэслэн 9,750,000 төгрөгөөр дүүргийн нутаг дэвсгэрт бүртгэлтэй гэрийн тэжээзвэр 7634 амьтанг гоц халдварт, халдварт өвчинеэс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулсан. Мөн вакцинжуулалт, туулгалт, ариутгал халдвартгүйтгэлийг "Содхан" мал эмнэлэгтэй хамтран 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрөөс 2022 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийт хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэсэн.</p> |
|---|---|--|------------------|--|

#### ЗГ-ын тогтоол

|   |  |   |          |   |
|---|--|---|----------|---|
| 4 |  | <p>1.. Дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, териин өмчийт болон териин өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт үүрэг болгосуяг:</p> <p>1.1. харьяа байгууллага болон салбар, нэгжид сахилга, дэг журмыг сахиулах тодорхой арга хэмжээ авч, териин албаны хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг зерчсэн териин албан хаагчид хариуцлага тооцож тухай бүр Засгийн газрын Хэрэг зэрхэг газарт тайлagnаж байх;</p> | Төсөвгүй | <p>Териин албаны хууль, холбогдох дүрэм, журмыг үндэслэн сахилга дэг журмыг сахиулах зорилгоор Засаг даргын зэрхэг зорилтуудын хурээний харьяа 14 байгууллагын удирдах албан тушаалтанд удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хангаптгүй биелүүлсэн, сахилга, дэг журмын зөрчил гаргасан зэрэг үндэслэлээр сонсох ажиллагаа явуулж, сахилгын шийтгэл ногдуулсан.</p>   |
| 5 |  | <p>1.2. иргэдийг ялгаварлан гадуурхахгүй ижил тэгш, зөв шударга харьцаж, териин байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдлыг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдөрт багтаан шийдвэрлэж, хариуг өгөх, цаашид өргөдөл, гомдлыг хугацаанд нь бодитой шийдвэрлэж хэвшүүлэх;</p>   | Төсөвгүй | <p>Иргэдээс нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар, хороод, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадад 2022 онд нийт 4007 өргөдөл, гомдол ирснээс 94.0 хувь буюу 3776 өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, 1 хувь буюу 45 өргөдөл, гомдлыг хугацаа хэтэрч шийдвэрлэж, 4 хувь буюу 186 өргөдөл, гомдол судлгагдж байна. Шийдвэрлэж хариу өгсөн 2938 өргөдөл, гомдлын 74.4 хувь буюу 2187 гомдлыг бүрэн барагдуулж, 16.4 хувь буюу 482 гомдолд боломжгүй тухай хариу өгч, 9.2 хувь буюу 269 гомдлыг бүрэн барагдуулж шийдвэрлэгүй, зөвхөн холбогдох тайлбар, мэдээллийг өгч хаасан байна.</p> |

|   |  |          |  |
|---|--|----------|--|
| 6 | <p>1.3. төрийн албан хаагчдын ажлын байрны шинжилгээ хийж, шинжилгээний дунд тулгуурлан байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах;</p>  | Төсөвгүй | <p>Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/72 дугаар тушаалыг үндэслэн 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс 04 дүгээр сарын 15-ны өдриүүдэд Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албадын дарга, ахлах мэргэжилтэн, мэргэжилтний ажлын байранд иж бүрэн дүн шинжилгээ хийж, холбогдох тайлан, мэдээллийг Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлж нийт 7 албан тушаалын тодорхойлолтыг шинээр батлуулж, 4 албан тушаалын тодорхойлолтыг өөрчлөн батлуулсан.</p>  |
| 7 | <p>1.4. төрийн жинхэнэ албан тушаанд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нехэн томилох замаар төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх;</p>   | Төсөвгүй | <p>Төрийн жинхэнэ албан тушаалын 22 сул орон тооны захиалгыг 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлсэн ба шаардлага хангасан 19 албан тушаалын сул орон тоог нехех сонгон шалгаруулалт 2022 оны 11 дүгээр сарын 22, 23-ны өдриүүдэд зохион байгуулагдахаар зарлагдаад байна.</p>  |
| 8 | <p>1.5. төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын удирдах албан тушаанд албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаа удирдах албан тушаалтнуудын сонгон шалгаруулалтын захиалгыг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, сонгон шалгаруулалтын дагуу удирдах албан тушаалтныг томилох;</p>   | Төсөвгүй | <p>Тус дүүргийн Ерөнхий боловсролын 17, 37, 50, 57, 117, 140, 145, 149 дүгээр сургуулийн захирлын, 5, 19, 56, 245, 258, 275, 277, 280, 291, 292, 293, 298 дугаар цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалын сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлж, сонгон шалгаруулалтын дагуу удирдах албан тушаалтнуудыг томилон ажиллаж байна. Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга, Нийгмийн хөгжлийн хэлтсийн даргын албан тушаалын сул орон тооны захиалгыг 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлсэн ба тус албан тушаалуудын сул орон тоог нехех сонгон шалгаруулалт 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулагдахаар зарлагдаад байна.</p> |
| 9 | <p>1.6. төрийн жинхэнэ албан хаагч жиремсний болон амаржсны амралттай байгаа, эсхүл 3 сараас дээш хугацааны сургалтад хамрагдаж сул орон тоо гарснаас бусад тохиолдолд төрийн албаны сул орон тоонд гэрзэт ажилтан томилохгүй байх зарчим баримталж, төрийн байгууллагад албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн богино хугацаагаар Засаг даргын Тамгын газарт болон Засаг даргын дэргэдэх хэлтэст нийт 4 гэрзэт ажилтныг ажиллуулж байх;</p> | Төсөвгүй | <p>Дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, алба, хороодын төрийн захиргааны албан тушаалын сул орон тоонд гэрзэт ажилтан томилоогүй байна. Төрийн байгууллагын албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн богино хугацаагаар Засаг даргын Тамгын газарт болон Засаг даргын дэргэдэх хэлтэст нийт 4 гэрзэт ажилтныг ажиллуулж байна.</p>  |

|   |    |  |          |   |
|---|----|--|----------|---|
|   |    |  |          |   |
| 4 | 10 | <p>Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018-08-22 Дугаар 2018_258</p> <p>1.7. төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган хориглож, зерчсэн тохиолдолд хариуцлага тооцох;</p> | Төсөвгүй | <p>Дүүргийн Засаг даргын 2013 оны А/387 дугаар захирамжаар батлагдаж, одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Хөдөлмерийн дотоод журмын 5.3.10-т "Ажлын байранд буюу албан үүргээ гүйцэтгэх согтууруулах ундаа хэрэглэх", 5.3.11-т "Ажлын байранд тамхи татах" зэргийг хориглосон байдал. Хөдөлмерийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны А/96 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлыг хэсэг Хөдөлмерийн дотоод журмыг шинэчлэн боловсруулж, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг хориглох заалтуудыг тусгахаар ажиллаж байна.</p>   |
|   | 11 | <p>1.8. төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зерчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах;</p>   | Төсөвгүй | <p>Төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зерчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах;</p> <p>Төрийн албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн үндэс, төрийн албаны үнэт зүйл, төрийн албан хаагчийн ёс зүйтэй шийтвэр гаргалтын талаар мэдлэг олгох зорилго бүхий "Төрийн албан хаагчийн ёс зүй ба байгууллагын соёлоо бүтээх нь" сэдэвт сургалтад 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулж, Засаг даргын Тамгын газрын нийт 56 ажилтан, албан хаагчийг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний наецийн хөгжлийн төвөөс 2022 оны 10 дугаар сарын 10-13-ны өдрүүдэд зохион байгуулсан "Стресс менежмент, Төрийн албан хаагчийн ёс зүй" сургалтад Засаг даргын Тамгын газар, хороодын 10 албан хаагчийг тус тус хамруулсан. 2022 оны 3 дугаар улирлын байдлаар иргэдээс ёс зүйн зөрчил гаргасан 3 албан хаагчтай холбоотой гомдол ирсэн бөгөөд 2 албан хаагчийн асуудлыг холбогдох журмын дагуу шийдвэрлэж, 1 албан хаагчийг асуудлыг. Ёс зүйн зөвлөлийн хурлаар хэлэлцэн, цааш судалж байна. Түүнчлэн удирдлагаас албан ёсоор зөвшөөрөл авалгүйгээр ажил тасалсан, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хангалтгүй биелүүлсэн 9 албан хаагчид мэдэгдэх хуудас хургуулэн сонсох ажиллагаа явуулж, тайлбар авч, дахин алдаа дутагдал гаргахгүй байх талаар сануулга өгсөн.</p> |

|    |  |          |   |
|----|--|----------|---|
|    |  |          |   |
| 12 | 1.9. төрийн байгууллагад ажлын цаг ашиглалтыг хурууны хээний болон камерын хяналтын системээр байнга бүртгэж, түүнд тавих хяналтыг сайжруулах.   | Төсөвгүй | Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дуургийн Засаг даргын Тамгын газрын бүх ажилтан, албан хаагчдын "Ажлын цагийн бүртгэл"-ийг царай таних төхөөрөмжөөр бүртгэж байна. Албан хаагчдын цагийн бүртгэлийг цаг бүртгэлийн системээс татан авч, удирдлагад танилцуулан ажиллаж байгаа бөгөөд дуургийн Засаг даргын Тамгын газрын Дотоод журмын 6.5.3 дахь заалтыг ундэслэн ажлаас хоцорсон 1 минутыг 100 төгрөгөөр тооцон цалингаас суутгах арга хэмжээг авч ажиллаж байна. |
| 13 | 1.10. ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар байгууллагын дотоод журамд тусган мөрдүүлж, зөрөг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бурдуулэх арга хэмжээ авах;   | Төсөвгүй | Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг шинчлэн байгуулах Ажлын хэсгийг Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн A/96 дугаар тушаалаар байгуулсан бөгөөд хөдөлмөрийн дотоод журмын төсөлд албан хаагчдыг жендэрийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамт үзүүлэхээс ангид байлгах зорилгоор ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй холбоотой гомдолыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хүрээнд хянан шийдвэрлэх талаарх холбогдох заалтуудыг тусган ажиллаж байна.                            |
| 14 | 3.. Төрийн албаны соёл, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор гэнэтийн болон төлөвлөгөөт хяналт шалгалтыг холбогдох байгууллагатай хамтран төрийн байгууллагуудад тогтмол зохион байгуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатарт, өөрийн эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллагад хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт тус тус даалгасугай. | Төсөвгүй | Дуургийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн A/291 дүгээр тушаалаар Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын сахилга хариуцлагыг нэмэгдүүлэх хүрээнд албан хаагчдын зүй зохистой хувцаслалт, ажлын цаг ашиглалт, ажлын байрны аюулгүй байдал, ажлын байрны эмх цэгц, харуул хамгаалалтад хяналт шалгалт хийх Ажлын хэсгийг байгуулсан ба хяналт шалтгалтыг хийх төлөвлөгөө, хуваарийг боловсруулж, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.   |

Еренхий сайдын захирамж

|   |   |   |           |   |
|---|---|---|-----------|---|
|   |   |   |           |   |
|   | 15  | 1.1. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын гамшиг, гал түймэр, ослын аюулаас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангуулах, барилга байгууламжид тавигдах шаардлагыг газар дээр нь шалгаж, үнэлэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэхийг Монгол Улсын Шадар сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Барилга, хот байгуулалтын сайд нарт, дээрх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж оролцох, хамаарах нутаг дэвсгэр, салбар, байгууллагын холбогдох чиглэлийн үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга нарт; | Төсөөвгүй | Дүүргийн Засаг даргын 2021 оны А/165 дугаар захирамжаар "Дүүргийн гамшигаас хамгаалах алба, мэргэжлийн анги, ажлын хэсгийг шинэчлэн байгуулах, ажиллах журам батлах тухай" ажлын хэсэг байгуулагдаж 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдөр хуралдсан. Хурлаар хүчтэй цасан ба ширеен шуурга, ган зуд, хөлдөлт, үер усны аюул, газар хөдлөлтийн үед ажиллах хүч, техник хэрэгслийг тодотгож, мэргэжлийн байгууллагуудад үүрэг өгч ажилласан. Мен дүүргийн Онцгой байдлын хэлтсийн даргын 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн албан бичгээр гамшигаас хамгаалах алба, мэргэжлийн антиудын бэлэн байдлыг хангах, хүч хэрэгслийг тодотгох талаар албан бичиг хургуулсан.   |
| 5 | Гамшиг, галын аюулгүй байдлыг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2018-04-06<br>Дугаар<br>2018_68 | 1.3. Зориулалтын бус барилга байгууламжид иргэд, олон нийтийг хамруулсан үйл ажиллагаа зохион байгуулсаас хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй хэрэг зөрчил гарч байгаа явдлыг илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд болон бүх шатны Засаг дарга нарт;  | Төсөөвгүй | Онцгой байдлын еренхий газрын даргын 2022 оны "Барилгын материал, мод модон здэлэлийн үйлдвэрлэлийн барилга байгууламжид Гамшигаас хамгаалах болон Галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөө болон гүйцэтгэлийн хяналт шалгалт явуулах тухай" удирдамжийн хүрээнд Онцгой байдлын хэлтсийн Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, Гал түймрийн улсын хяналтын байцаагч нар 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн хооронд хяналт шалгалтыг зохион байгуулан ажиллаа. Хяналт шалгалтыг тус дүүргийн нутаг дэвсгэрт байршилтай нийт 32 Барилгын материал, мод модон здэлэлийн үйлдвэрлэлийн барилга байгууламжид Монгол улсын Гамшигаас хамгаалах тухай болон Галын аюулгүй байдлын тухай хууль, Гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын шаардлагыг тодорхойлсон стандарт техникийн нормативыг үндэслэн хэрэгжилтийг шалгахад 15 зөрчил илрүүлж, газар дээр нь арилгуулж, заавар зөвлөмж өгч ажилласан. |
|   | 17  | 1.5. Гамшиг, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлын шаардлагыг хангуулахтай холбоотой үйл ажиллагаанд өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүй мэргэжил, арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлж, уялдаа, зохион байгуулалтаар хангахыг Монгол Улсын Шадар сайд, бүх шатны Засаг дарга нарт.   | Төсөөвгүй | Дүүргийн еренхий зориулалтын мэргэжлийн анги, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, дүүрэг, хорооны гамшигаас хамгаалах сайн дурын хэсэг, бүлгийн гишүүд, иргэдэд гамшигаас хамгаалах сургалтыг нийт 194 удаа танхимаар зохион байгуулж 3545 албан хаагч, иргэн сургалтад хамрагдсан.  |

|                            |    |   |   |          |  |
|----------------------------|----|---|---|----------|--|
|                            |    |   |   |          |  |
| 6                          | 18 | 2018 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр 16 дугаар тэмдэглэл<br>2018-04-04<br>Дугаар<br>2018_16 | ХҮ.2. Ажлын байранд, ажлын цагаар интернет ашиглан олон нийтийн сүлжээнд нэвтрэх, албан ажилд хамаарахгүй үйл ажиллагаа явуулахыг хориглох асуудлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусган хэрэгжүүлж, териин албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах арга хэмжээ авч "Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" Засгийн газрын 2017 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нар, бүх шатны Засаг дарга, териин өмчтөй хуулийн этгээдийн захирлуудад үүрэг болгосугай. | Төсөвгүй | Хөдөлмөрийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан дуургийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны А/96 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлыг хэсгэг Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулж, ажлын байранд, ажлын цагаар интернет ашиглан олон нийтийн сүлжээнд нэвтрэх, албан ажилд хамаарахгүй үйл ажиллагаа явуулахыг хориглох тухай заалтуудыг тусгахаар ажиллаж байна.  |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл |    |   |   |          |  |
| 7                          | 19 | 2017 оны 8 дугаар сарын 9-ний өдөр 35 дүгээр тэмдэглэл<br>2017-08-09<br>Дугаар<br>2017_35 | ХХ.1. 4.. Аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд ургац хураалт, мал өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, байгаль цаг уурын болзошгүй хүндрэлзэс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг батлан, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллах, хадлан, ногоон тэжээл болон бусад тэжээл бэлтгэх, худалдан авч неец бүрдүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.   | Төсөвгүй | Монгол Улсын Еренхий сайдын "2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын болон ургац хураалтын бэлтгэл хангах тухай" 09 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг ханган, Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 03/232 дугаартай албан бичгийн дагуу дүүргийн хэмжээнд нийт 12.8 га-д темс, хүнсний ногоо тариалсанаас 11.6 га талбайд хураалт хийсэн.   |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл |    |   |   |          |  |
| 8                          | 20 | 2017 оны 7 дугаар сарын 18-ны өдөр 34 дүгээр тэмдэглэл<br>2017-07-18<br>Дугаар<br>2017_34 | XIII.5. 5.2.оин түймэр, хенеөлт шавж, өвчинд нэрвэгдсэн, хүчтэй салхи, их цасанд өртөн амьдрах чадваргүй болсон унанга мод, гишүү, мечир, мод бэлтгэлийн талбайн үлдэгдлийг цэвэрлэх ажлыг ойн мэргэжлийн нэхөрлөл, байгууллага болон хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан ажиллуулах замаар зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, бүх шатны Засаг дарга нарт;  | Төсөвгүй | Улаанбаатар хотын Еренхий менежерийн 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн Бүх нийтийн их цэвэрлэгээний ажил зохион байгуулах тухай А/08 дугаар тушаалын дагуу дүүргийн 19 дүгээр хорооны зуслангийн бүсийн нутаг дэвсгэрийг хамарсан цэвэрлэгээний ажлыг зохион байгуулан ажиллаа.<br>Их цэвэрлэгээгээр Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээ ХХК "Найши трейд" ХХК-ний харьяа иргэдийн бүлгийн 30 гаруй иргэн, зам талбайн 20 гаруй үйлчлэгч, 2 ХХАА ажилтан Тээвэрлэгч байгууллагуудын 20 ачигч, жолооч, оролцож нийт 60 гаруй хүн цэвэрлэгээний ажилд хамрагдан 71,000 м2 гаруй цэвэрлэгээг, зуслангийн бүсийн амууд, ой мод, гу жалга далан суваг зэрэг газаруудыг цэвэрлэн ажиллаа.<br>Цэвэрлэгээнээс гарсан хог хаягдлыг хог тээвэрлэгч байгууллага 20 машинаар хог тээвэрлэлт хийж нийт 179 тн хог хаягдлыг 32 рейс хийн ачиж тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт хүргүүлэн ажилласан. |
| Еренхийлэгчийн зарлиг      |    |   |   |          |  |

|                |    |  |   |          |  |
|----------------|----|--|---|----------|--|
|                |    |  |   |          |  |
| 9              | 21 | Нутаг орны газар зүйн нэрийг хамгаалах тухай 2017-07-10 Дугаар 2017_186                | 1.. Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1, Монгол Улсын Ерөнхийлгэчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГБОЛГОХ нь: 1. Монгол Улсын Их Хурлын 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 42 дугаар тогтооюур баталсан "Монгол Улсын нутаг дэвсгэрийн газар зүйн нэрийн жагсаалт" дахь газар усны газар зүйн нэрийг албан хэрэг, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд мөрдүүлэх, тухайн орон нутагтаа ард иргэдийн дунд сэргээн хэвшүүлэх, цаашид хууль бусаар газар орны нэр веерчлех гэмт явдалтай хууль тогтоомжийн дагуу тууштай тэмцэхийг бүх шатны Засаг дарга наарт үүрэг болгосугай. 2. Уул ус, газар нутгаа эрх бүхий байгууллагаас баталсан нэрээр зөв нэрлэж занших, веерчлен буруу нэршихээс сэргийлэх, монгол хэлнээс бусад хэлээр орчуулах буюу бусад хэлний дуудлагаар галиглахгүй байхыг Монгол Улсын нийт иргэд, байгууллагад уриалсугай. | Төсөвгүй | Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 174 дүгээр тогтоолын дагуу дүүргийн түүхт 30 жилийн ойн хүрээнд Чингэлтэй хайрхны лус савдгийг баясан тахиж, тэдний ивээлд багтан буян хишгийг нь иргэдээс хүртээх, дүүргийн ирээдүйн хөгжил, иргэдийн сайн сайхан амьдралыг даатгах, хайрхан уулын тэнгэр, сахиусыг тайх их тайлга тахилгын ёслолыг намрын тэргүүн сарын шинийн 30-ны бэлэгт сайн өдөр буюу 2022 оны 09 дүгээр сарын 25-нд зохион байгуулсан. Үйл ажиллагааны үеэр шар торгон дээр хуучин монгол бичгээр бичсэн Чингэлтэй хайрхны захирамжийн айлтталын бичгийг тусгайлсан ширээнд хүндэтгэн залж, "Дашчоймбол" хийдийн лам хуврагууд тусгай дэг жаягийн дагуу буян номын хур буулгаж хайрханы сахиусыг аргадаж тайлсан бөгөөд их овооны зуун, баруун талын сорогчинд таван өнгийн хадаг уяж, морь сэтэрлэх зан үйлийг үйлдсэн юм. |
| 10             | 22 | Хадны зураг, бичээсийг хамгаалах, судлах ажлыг дэмжих тухай 2017-07-09 Дугаар 2017_181 | 2.. Хадны зураг, бичээсийг хадгалж хамгаалах, дэлхий дахинаа сурталчлан таниулах, аялал жуулчлалын шинэ хэлбэрийг хөгжүүлэх зорилгоор өргөн хүрээтэй, үр дүнтэй ажил зохион байгуулахыг бүх шатны засаг захирагааны байгууллагууд, төрийн болон төрийн бус байгууллага; шинжлэх ухаан, нийгэм соёлын зүтгэлтнүүд, аялал жуулчлалын байгууллага, ард иргэдэд уриалсугай.   | Төсөвгүй | Чингэлтэй дүүргийн Соёлын төвийн дугуйлан секцэд хамрагддаг тусгай хэрэгцээт нийт 20 сурагчдад түүх, соёлын дурсгалт өвийг сурталчлан таниулах зорилгоор "Чингис хааны музей"-т 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдөр үзүүлсэн.  |
| ҮИХ-ын тогтоол |    |  |   |          |  |
| 11             | 23 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний       | 1.5.. Бүх шатны Засаг даргын үр дүнгийн гэрзэнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн зруул мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс, сургалтын байгууллагын үйл ажиллагааг дэмжих, тухайн орон нутгийнхаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, сувилалд тэгш хамруулах асуудлыг тусгаж, үүрэгжүүлж ажиллах;   | Төсөвгүй | Дүүргийн Засаг даргын 2022 оны А/34 дүгээр захирамжаар дүүргийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн зруул мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүдийг шинэчлэн байгуулгадж 10 хурагдан, нийт 364 хүүхдэд байнгын асаргаа тогтоож, халамж, боловсролын үйлчилгээнд хамруулсан байна. Дүүргийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/54 дүгээр захирамжаар Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн "Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл"-ийг шинэчлэн байгуулсан Зөвлөлийн хурлаар 9 өргөдлийн дагуу хүүхдүүдийг сургууль, цэцэрлэгт хамруулсан Дүүргийн хэмжээнд нийт 570 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байдгаас 2022-2023 оны хичээлийн жилд СӨББ-д 60 хүүхэд, ЕБС-д 25 хүүхэд хамрагдсан.   |

|               |    |  |  |          |  |
|---------------|----|--|--|----------|--|
|               |    | тухай<br>2017-06-09<br>Дугаар 2017<br>№46  | 1.10.. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэнийг хөгжүүлэх төвүүдийг аймаг, дүүрэгт байгуулах;   | Төсөвгүй | Алслагдсан хороодын хүүхэд багачуудын сурч боловсрох, өөрсдийгээ хөгжүүлэх, ном хэвлэл унших эрхийг нь хангах хүрээнд "Гүүд нэйборс Монголиа" Олон улсын төрийн бус байгууллагатай Санамж бичиг байгуулан, дүүргийн 16 дугаар хороонд байрлах Ботгоон номын санг дүүргийн Хүүхдийн номын өргөөний салбар номын сан болгон ажиллуулж байна. Мөн дүүргийн Хүүхдийн Номын өргөөгөөр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд үйлчлүүлэх боломжийг бурдуулж тусгай булан байгуулж, брайл үсгээр ном бүтээсэн.   |
| 12            | 25 | 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр 55 дугаар тэмдэглэл 2016-11-16 Дугаар 2016_55                  | XXVI.5.4. Малын гоц халдварт өвчинд тавих хяналтыг сайжруулах, өвөлжилт, хаваржилт хүндрэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор байнгын бэлэн байдалд шилжиж, цаг хүндэрсэн нутаг дэвсгэрт өвөлжиж байгаа малчдад дэмжлэг, туслалцаа тогтмол үзүүлж ажиллахыг бүх шатны Засаг дарга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргээн нарт тус тус даалгав. | Төсөвгүй | Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны "Нийслэлийн нутаг дэвсгэрт мал аж ахуй эрхлэх журам" 85 дугаар тогтоол, 2019 оны "Мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрөх буюу хориглох бусийн хил хязгаарыг шинэчлэн батлах тухай" 21/06 дугаар тогтоолоор Чингэлтэй дүүргэж мал аж ахуй эрхлэхийг хориглосон бусэд багтдаг  |
| ЗГ-ын тогтоол |    |  |  |          |  |
| 14            | 28 | Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай<br>2014-05-10<br>Дугаар<br>2014_147 | 1.3.бүх шатны Засаг даргын орлогч, төсөвт байгууллагын дэд дарга, яам, агентлагийн газрын орлогч дарга, даргын туслах, төсвөөс цалинждаг зөвлөх зэрэг орон тоог цөөлөх, цомхтхох   | Төсөвгүй | Төрийн хэмнэлтийн тухай хуульд дүүргийн Засаг дарга нэгээс илүүгүй орлогчтой байна гэж заасны дагуу хууль тогтоомж, дээд байгууллагын шийдвэрийн биелэлтийг хангах хүрээнд тус дүүргийн Засаг даргын 2022 оны Б/72 дугаар захирамжийг үндэслэн Инновац, хөгжлийн асуудал хариуцсан орлогч, Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч, Ногоон байгууламж, бохирдлын асуудал хариуцсан орлогч нарыг ажил, албан тушаалаас нь чөлөөлж, дүүргийн Засаг даргын 2022 оны Б/81 дүгээр захирамжаар Дэд бүтэц, төлөвлөлтийн асуудал хариуцсан орлогчийг дүүргийн Засаг даргын орлогч гэж өөрчилж, Засаг даргын 1 орлогчтой болгосон. |
|               | 29 |  | 1.4.төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах үүрэгтэй харуул хамгаалалт, халаалт дулаан, цэвэрлэгээ зэрэг үйлчилгээг гэрээний үндсэн дээр хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх, төрийн албаны гэрээт ажилтны орон тоог 50 хувиар бууруулах санал боловсруулж шийдвэрлүүлэх  | Төсөвгүй | 2022 оны 3 дугаар улирлын байдаар байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах үүрэгтэй харуул хамгаалалт, халаалт дулаан, цэвэрлэгээ зэрэг үйлчилгээг гүйцэтгэж буй гэрээт ажилтан байхгүй байна.  |

ХЯНАСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

НЭГТГЭСЭН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН МЭРГЭЖИЛТЭН

Л.БАЯРМАА  
Дамшиг:

ГАНЧИМЭГ